



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар A/261

Ховд

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Ховд аймгийн Онцгой комиссын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 08 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвлийн халаалтын улирал дуусаж байгаатай холбогдуулан Жаргалант сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн дулааны шугам сүлжээнд өндөр даралтын шахалт хийж яаралтай солих зайлшгүй шаардлагатай паар болон шугам сүлжээний дүгнэлт гаргаж, сольж шинэчлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

Ахлагч: Ц.Цогтбаяр

-Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Ц.Жаргалсайхан

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн шугам сүлжээ хариуцсан мэргэжилтэн

Х.Баярлах

-Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

2.Яаралтай солих, шинэчлэх ажлын тоо хэмжээг тооцсон төсвийн хамт гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Цогтбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ

Т. ЖАРГАЛСАЙХАН

Zax A/261 Ch  
02 01301